

32

ХУУЛЬ ЗҮЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2013 оны 1 сарын 15 өдөр

Дугаар А/05/10


Улаанбаатар хот

Журмын заалт хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2002 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 313/316 дугаар тушаалаар баталсан “Ялаас чөлөөлөх өвчний жагсаалт, хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн бусад байгууллагын туслалцаа үзүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хүнд, онц хүнд гэмт хэрэгт шийтгүүлсэн болон чанга, түүнээс дээш дэглэмд ял эдэлж байгаа ялтныг клиникийн эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төв, орон нутгийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлж эмчлэхийг хориглоно” гэсэн заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэхүү тушаалыг 2013 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн даган мөрдөж биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /дарга, хурандаа Д.Ядамдорж/, клиникийн эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэгийн захирал, дарга нарт даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Х.ТЭМҮҮЖИН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Н.УДВАЛ